



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2017 он 04 дугаар  
сарын 14-ны өдөр

Дугаар Хэт/606


Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
М.ЭНХБОЛД ТАНАА

Ерөнхий сайдын мэдээллийн тухай

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Улсын Их Хурлын 2017 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд хаврын тариалалтын бэлтгэл ажлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл хийх болсныг Танд үүгээр уламжилж байна.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Ж.МӨНХБАТ

**2017 ОНЫ ХАВРЫН ТАРИАЛАЛТЫН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР  
АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНД МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
Ж.ЭРДЭНЭБАТЫН ХИЙХ МЭДЭЭЛЭЛ**

2017 онд улсын хэмжээгээр 381.6 мянган га-д үр тариа (үүнээс 362.1 мянган га-д улаанбуудай), 15.1 мянган га-д төмс, 8.5 мянган га-д хүнсний ногоо, 23.2 мянган га-д тэжээлийн таримал, 28.6 мянган га-д тосны ургамал, 1.0 мянган га-д жимс жимсгэнэ, нийтдээ 458.0 мянган га-д тариалалт хийж, 498.5 мянган тонн үр тариа, үүнээс 477.6 мянган тонн улаанбуудай, 166.5 мянган тонн төмс, 102.1 мянган тонн хүнсний ногоо, 46.4 мянган тонн малын тэжээл, 22.8 мянган тонн тосны ургамал, 4.0 мянган тонн жимс, жимсгэнэ тус тус хураан авах зорилтыг дэвшүүлж, хаврын тариалалтын бэлтгэлийг ханган ажиллаж байна.

Энэхүү зорилтын хүрээнд үр тариа, тос, тэжээлийн таримлын тариалалтыг 14 аймгийн 1360 гаруй аж ахуйн нэгж, иргэн, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний тариалалтыг 468 аж ахуйн нэгж, хоршоо, 35.0 мянган өрхийн хэмжээнд тариалахаар төлөвлөж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэн бүр бэлтгэлээ хангаж байна.

Засгийн газраас Тариалангийн тухай хууль, Таримал ургамлын үр, сортын тухай хууль, Ургамал хамгааллын тухай хууль, Үрийн тариалангийн даатгалын тухай хууль болон Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-д дэвшүүлсэн болон Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.39-2.47-д тусгагдсан тариалангийн талаарх зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна.

Засгийн газраас 2016 оны “Үндэсний аян өрнүүлэх тухай” 212 дугаар тогтоол баталж, “Атрын-III” аяныг үргэлжлүүлэхээр тогтож, энэ ажлыг зохион байгуулах талаар тодорхой шийдвэр гарган ажиллаж байна.

Хаврын тариалалтын бэлтгэл ажлыг газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн бүр хангаж байгаа ч, улс, орон нутгийн зүгээс авч хэрэгжүүлэх зохион байгуулалтын ажил, техник, технологийн дэмжлэг үзүүлэхтэй холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам улсын хэмжээнд, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар аймгуудын хэмжээнд, Хүнс, хөдөө аж ахуйн газар тухайн аймаг, нийслэлийн хэмжээнд тариалалтын бэлтгэл хангах төлөвлөгөө гарган дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Хаврын тариалалтын бэлтгэл ажлын хүрээнд одоогийн байдлаар Говь-Алтай, Дорноговь, Орхон, Хөвсгөл, Увс, Төв аймаг ногоочдын зөвлөгөөн зохион байгуулсан бөгөөд эдгээр зөвлөгөөнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас төлөөлөл оролцож тариалангийн талаарх 2017 оны зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээгээ танилцуулан санал аван ажиллаж байна.

2. Мөн яамнаас “Байцаа, сонгино, сармисны үрсэлгээ бойжуулах, тарих технологи, ургамал хамгаалал” сэдвээр Орхон, Хөвсгөл, Увс аймагт сургалт зохион байгуулж 185 гаруй ногоочдыг хамруулсан байна. Мөн үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний суулгац үржүүлэх тусгай зөвшөөрөл олгох сургалтыг Увс аймагт зохион байгуулсан.

3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нийтдээ 22 аймаг, нийслэлийн 6 дүүргийн 500 гаруй тариаланчид, ногоочид, тариалангийн салбарын удирдах ажилтан, мэргэжилтнүүдийг оролцуулсан Улсын зөвлөгөөнийг 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулахаар бэлтгэж байна. Энэ зөвлөгөөний үеэр хаврын тариалалтын бэлтгэл хангах талаар Тариалан эрхлэлтийг дэмжих сан болон аж ахуйн нэгж хооронд, аж ахуйн нэгж хооронд олон талт гэрээ хэлцэл хийгдэхээр төлөвлөж байна.

Уг зөвлөгөөний үеэр дулааны улирлын цаг агаарын төлөв байдал, таримал ургамал тариалах ерөнхий технологи зэрэг эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, Ус, цаг уурын хүрээлэнгийн зөвлөмжүүдийг аж ахуйн нэгж, иргэн, газар тариалангийн мэргэжилтэн нарт танилцуулна.

Хаврын тариалалтын бэлтгэл хангах талаар хэрэгжүүлж байгаа ажлын урьдчилсан дүнгийн талаар авч үзвэл,

#### ***Нэг. Үр, шатахууны хүрэлцээ хангамжийн талаар:***

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам тариалах талбай, шаардагдах үрийн захиалгыг орон нутгаас хүлээн авч дутагдах үрийг хангах талаар дараах арга хэмжээ авч байна.

1. Энэ оны хаврын тариалалтад нийтдээ улаанбуудайн үр 54.3 мянган тонн шаардагдахаас аж ахуйн нэгжүүд 2016 оны ургацаас 39.8 мянган тонн, Тариалан эрхлэлтийг дэмжих санд 4.6 мянган тонн, Онцгой байдлын ерөнхий газрын Улсын үрийн нөөцийн салбарт 5.8 мянган тонн, нийтдээ 50.2 мянган тонн үрийн нөөц бүрдээд байна. Түүнчлэн тариалан эрхэлдэг томоохон аж ахуйн нэгжүүдэд 2.0-3.0 мянган тонн үрийн илүүдэл нөөц байгаа гэсэн судалгааг нэмж тооцвол 2017 онд төлөвлөсөн хэмжээндээ тариалалт хийхэд шаардагдах үрийн нөөц бүрдсэн гэж үзэх боломжтой.

Мөн хэрэгцээт үрийнхээ тодорхой хувийг өөрийн зардлаар шинэчлэхээр хүсэлт ирүүлсэн 8 аж ахуйн нэгжид 820 тонн үрийн буудай импортоор авах зөвшөөрлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас олгосон байна.

2. Тариалалтад зориулан нөөцөлсөн буудайн үрийг цэвэрлэж дугаарлан стандартад тэнцүүлэх, нарлуулах, ариутгах ажил үр хадгалж байгаа аж ахуйн нэгж болон Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн агуулахуудад хийгдэж байна.

3. Энэ оны хаврын тариалалтад 7.1 мянган тонн, уринш боловсруулалтад 7.9 мянган тонн, ургац хураалтад 5.4 мянган тонн, нийтдээ газар тариалангийн үйлдвэрлэлд 20.4 мянган тонн дизелийн түлш шаардагдах тооцоог аж ахуйн

нэгжүүдээс хүлээн авч холбогдох мэргэжлийн байгууллагад мэдээлэл хүргүүлэн нөөцийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох талууд хамтран ажиллаж байна.

4. Тариалалтын ажлыг технологийн хугацаанд чанар сайтай гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх, тариаланчдад учрах санхүүгийн дарамтыг бууруулах зорилгоор дутагдах үрийн буудайг 40 хувийн, шатахууныг 50 хувийн урьдчилгаатайгаар зээлээр олгож, үлдэгдэл төлбөрийг намрын ургацаас нөхөн бүрдүүлэхээр шийдвэрлэн гэрээ байгуулах бэлтгэлийг хангаж байна. Эдгээр арга хэмжээг Тариалан эрхлэлтийг дэмжих сан холбогдох аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан зохион байгуулж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хүнсний ногооны нэр төрөл, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, техник, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах, голлох нэрийн хүнсний ногоогоор дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах зорилгоор “Хүнсний ногоо” хөтөлбөрийн төслийг ногоочид, тариаланчдын саналыг аван боловсруулж байна.

5. Төмсний тариалалтад нийтдээ 39.5 мянган тонн үрийн хэрэгцээ байгаа бөгөөд аж ахуйн нэгж, хоршоо, иргэд хэрэгцээт үрээ бүрэн нөөцөлсөн мэдээтэй байна. Эрдэм шинжилгээний байгууллагатай хийсэн гэрээний дагуу вирусгүй бичил булцуунаас төмсний 32 тн супер элит үр үйлдвэрлүүлж, аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газраар дамжуулан үр шинэчлэлд зориулан олгож эхлээд байна.

“Хүнсний ногооны тогтвортой үйлдвэрлэл ба маркетинг” төслийн хүрээнд 75 тонн төл сонгины үрийг Голланд Улсаас импортлохоор бэлтгэлээ.

#### ***Хоёр. Техникийн бэлэн байдлын талаар:***

2017 оны хаврын тариалалтад зүтгэх хүчний трактор 2980, үр тарианы үрлүүр 2017, хөрс боловсруулах техник 5787, төмс, хүнсний ногооны үрлүүр 498 ажиллах бөгөөд техникийн засвар, үйлчилгээний ажил аж ахуйн нэгжүүд өөрсдөө хариуцан хийж байна.

БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн 24.5 сая ам.долларын хөрөнгөөр хөдөө аж ахуйн техник, усалгааны тоног төхөөрөмжийг худалдан авах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас цаашид газар тариалангийн салбарт техникийн шинэчлэл хийх санхүүжилтийн схем, төслийг боловсруулан гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хүсэлтийг Монгол Улсын Хөгжлийн банк, Сангийн яаманд хүргүүлээд байна.

Мөн яам Монгол Улсын Хөгжлийн банкт хамтарч “Хөдөө аж ахуйн техникийн лизинг” төсөл хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд Оросын Холбооны Улсад үйлдвэрлэсэн хөдөө аж ахуйн зориулалттай техникийг худалдан авахад зориулж Оросын ЭКЗИМ банкнаас 10.0 сая ам. долларын зээлийг 3-5 жилийн хугацаанд эргэн төлөх нөхцөлтэй авахаар уулзалт, хэлэлцээр хийгдэж байна.

Хөдөө аж ахуйн зориулалттай техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг гаалийн албан татвараас чөлөөлөх хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулан холбогдох яамдаас санал авч Засгийн газраар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас 125 морины хүчтэй трактор, услалтын намираа систем, хүнсний ногооны үрлүүр, үрсэлгээ суулгагч, хөрс боловсруулах техникийг тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд 20 хувийн урьдчилгаа төлбөртэй 4 жилийн хугацаатай зээлээр олгох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Усалгаатай тариалангийн үр өгөөжийг дээшлүүлэх, услалтын системийн ашиглалтыг сайжруулах зорилгоор “Услалтын системийг эзэмших, ашиглах” журмын төслийг боловсруулан Байгаль орчин аялал жуулчлалын болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, Барилга хот байгуулалтын сайдуудын хамтарсан тушаалаар батлуулах ажил явагдаж байна. Бүгд Найрамдах Хятал Ард Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 7.9 мянган га талбайг услах хүчин чадал бүхий усалгааны тоног төхөөрөмж, бороожуулагч машиныг үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний тариалан эрхлэгчдийн захиалгын дагуу нийлүүлэхээр тендер зарлаж, хэрэгжилтийг зохион байгуулж байна.

Түүнчлэн Төв аймгийн Борнуур сумын Борнуурын услалтын системийн толгойн барилгын усны шүүрэлтийг зогсоох барилгын ажлын тооцоог хийж шаардагдах 2.0 сая ам.долларын төслийг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр шийдвэрлүүлэхээр хүргүүлээд байна. Услалтын системийг шинээр барьж, сэргээн засварлах ажилд 30.0 сая ам.долларын төслийн саналыг боловсруулж Азийн хөгжлийн банкинд хүргүүлсэн.

#### ***Гурав. Элеватор, зоорь агуулах, хадгалалт борлуулалтын талаар:***

Улсын хэмжээнд төмс, хүнсний ногооны зориулалттай 197.5 мянган тоннын багтаамжтай 9700 гаруй зоорь ашиглагдаж байгаа нь хүн амын хэрэгцээг бүрэн хангах зорилтот ургацын 56 хувийг хадгалах боломжтой байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын нийслэлийн Засаг даргатай байгуулсан санамж бичгийн хүрээнд Улаанбаатар хотод 10.0 мянган тоннын багтаамжтай агуулах бүхий хадгалалт, борлуулалтын цогцолбор төв байгуулах, томоохон аймгийн төвүүд болон төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн голлох сумдад тус бүр нь 1000 тоннын багтаамжтай 12 ногооны зоорь барих төслийн тооцоог боловсруулаад байна.

Хүнсний ногооны үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэхэд залуучуудыг татан оролцуулах, ахмад ногоочдын туршлагыг залуучуудад өвлүүлэх, төрөөс хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийг зорилтот бүлэгт хүргэж, нийгэмд үзүүлэх үр өгөөжийг нь дээшлүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай зөвшилцсөний дагуу “Залуу тариаланч” төслийн саналыг хамтран боловсруулж, Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэхээр бэлтгэлээ.

Зүүн бүсэд тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор 40.0 мянган тоннын багтаамжтай үр тарианы элеваторын аж ахуй байгуулах төслийн саналыг боловсруулав.

Шинээр байгуулагдаж байгаа зоорь, худалдааны төвүүдийг түшиглэн төмс, хүнсний ногоо хадгалан борлуулах логистик сүлжээ байгуулж, ногоочдын борлуулалтыг дэмжих, ченжийн дамжлагыг багасгах, хэрэглэгчдийг аюулгүй бүтээгдэхүүнээр хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

#### ***Дөрөв. Жимс, жимсгэний талаар:***

Жимс, жимсгэний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор “Жимс жимсгэнэ” хөтөлбөр боловсруулаад байна.

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын санхүүжилтээр “Жимс жимсгэний үйлдвэрлэлийг сайжруулах” төсөл хэрэгжүүлэхээр шийдвэрлэж нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулан, хүйтэнд тэсвэртэй алим, чавганы суулгацыг турших, нутагшуулах, мэргэжилтний чадавхийг сайжруулах ажлыг эхлүүлсэн.

Чацарганы зах зээл, маркетингийг сайжруулах, экспортыг нэмэгдүүлэх саналыг бэлтгэж Азийн хөгжлийн банкны “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чадавхийг нэмэгдүүлэх” төслийн бүрэлдэхүүн хэсэгт тусгуулав.

“Зах зээл бэлчээрийн менежмент” төслийн хүрээнд “Баруун бүсэд жимс жимсгэнэ тариалах технологи” сэдэвт сургалтыг Говь-Алтай аймагт зохион байгуулж 40 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулан сертификат олгосон.

Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн хүрээнд 5 га талбай бүхий өвлийн хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулах төсөл боловсруулж Монгол Улсын Хөгжлийн банк, Үндэсний хөгжлийн газарт хүргүүлж, төслийг судлах шатанд явагдаж байна.

Нийлэг хальсан болон шилэн хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулах төсөл боловсруулж Бүгд Найрамдах Солонгос Улс, Турк улсуудын хөнгөлөлттэй зээлд хамруулахаар санал хүргүүлээд байна.

#### ***Тав. Бордоо, ургамал хамгаалалын талаар:***

Газар тариалангийн үйлдвэрлэлд ургамал хамгаалалтын зориулалтаар ашиглаж болох пестицид, химийн бордооны жагсаалт болон тэдгээрийг хэрэглэх тун, хэмжээг гарган Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын нарын 2017 оны А/30, А/20, А/62 тоот хамтарсан тушаалаар батлан Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 3702 дугаарт бүртгүүлсэн нь хүнсний аюулгүй байдлыг хангах нэгэн арга хэмжээ болж байна.

Биологийн гаралтай бодисыг турших, бүртгэх, тэдгээрийг хэрэгжүүлэх, бүртгэлээс хасах, устгах салбар зөвлөлийн 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн хурлаар хөдөө аж ахуйд ургамал хамгаалах зорилгоор хэрэглэх биологийн гаралтай бодис, бордооны жагсаалтыг хэлэлцүүлэн батлуулж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны цахим хуудсанд байршуулсан.

Таримал ургамлын ургацыг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах зорилгоор Тариалан эрхлэлтийг дэмжих сангаар дамжуулан үр ариутгалын бодис 10 тонн, тарилтын үеийн хог ургамал устгах ургамал хамгааллын бодис 11.5 тонн, 130.0 мянган га талбайд химийн уринш боловсруулахад шаардагдах гербицид 500 тонн, нийлмэл бордоо 5000 тонныг тус тус нийлүүлж тариаланчдад хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох ажлыг зохион байгуулж байна.

### **ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

-Атрын гурав дахь аяныг үргэжлүүлэх зорилтын хүрээнд улаанбуудайн үрийн шинэчлэлийн бодлого, арга хэмжээ, “Жимс, жимсгэнэ”, “Хүнсний ногоо” дунд хугацааны хөтөлбөр, “Залуу тариаланч” төслийг эцэслэн боловсруулж батлуулан хэрэгжүүлэх;

-Тариалангийн салбарт техник, технологийн шинэчлэлийг эрчимжүүлэх, санхүүгийн түрээсийн үйлчилгээг нэвтрүүлэх;

-Тариалангийн даатгалын хууль тогтоомжийг боловсронгуй болгох;

-Хөрсний үржил шимийг хамгаалах, тариалангийн талбайн эзэмшилт, ашиглалтыг сайжруулах, бордоо, ургамал хамгаалалын бодисын зохистой хэрэглээг төлөвшүүлэх замаар хураан авах ургацын хэмжээг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах;

-Таримлын сэлгээн дэх ээлжийн тоог нэмэгдүүлэх, тэжээлийн болон буурцагт ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх;

-Тосны ургамлын тариалалтыг нийт тариалах талбайн 20 хувиас хэтрүүлэхгүй байх ажлыг орон нутгийн холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах зэрэг болно.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**